



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2025 оны 07 сарын 04 өдөр

Дугаар 332

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2, 8 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 2 дахь заалт, Засгийн газрын 2019 оны 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1, 6.4.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Улсын ерөнхий прокурорын газрын харьяа байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 3 нэрийн, нийт 20,671,425.60 (хорин сая зургаан зуун далан нэгэн мянга дөрвөн зуун хорин таван төгрөг жаран мөнгө) төгрөгийн балансын үнэ, 15,891,664.90 (арван таван сая найман зуун ерэн нэгэн мянга зургаан зуун жаран дөрвөн төгрөг ерэн мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийг хавсралтад заасны дагуу Хил хамгаалах ерөнхий газар (анги салбарт)-т балансаас балансад шилжүүлэхийг зөвшөөрсүгэй.

2. Улсын ерөнхий прокурорын туслах прокурор, Хэрэг эрхлэх газрын дарга С.Гансэлэм, Хил хамгаалах ерөнхий газрын дарга, Бригадын генерал Ж.Бямбасүрэн, хавсралтад заагдсан хуулийн этгээдийн дарга нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх, хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, удирдлага, зохицуулалтын цахим систем”-д бүртгэх;

2.3. Автотээврийн хэрэгслийг улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс шилжүүлж, арга хэмжээний биелэлтийг 2025 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТЭСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132001154

15-r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2025 оны дугаар сарын 01 ны/ний өдрийн
011 дугаар тогтоолын хавсралт

УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОРЫН ГАЗРЫН ХАРЪЯА БАЙГУУЛЛАГУУДЫН ГАЗРЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ,
ОБАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ АВТОМАШИНЫ ЖАГСААЛТ

Д/д	Автомашини нэр, төрөл, Улсын нэг болон арлын дугаар	Үйлдвэрлэгдсэн, ашиглалтад орсон огноо	Балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)	Автомашин шилжүүлэх байгууллагын нэр	Автомашин хүлээн авч бүртгэх байгууллагын нэр
4	Ниссан патрол маркийн 6263ДГН улсын, JN1TCSY61Z0581002 арлын дугаартай суудлын автомашин	1 2011/2011	7,333,333.30	6,111,111.00	1,222,222.30	Дорноговь аймгийн Замын Үүд сум дахь Сум дундын прокурорын газар	Хилийн цэргийн 0165 дугаар анги
5	Тоёото прадо 120 маркийн JTEBL29J40K004690 арлын, 4973 3АА улсын дугаартай суудлын автомашин	10 2007/2009	1,338,092.30	780,553.90	557,538.40	Завхан аймгийн Тосонцэнгэл сум дахь Сум дундын прокурорын газар	Хилийн цэргийн 0146 дугаар анги
9	Ниссан патрол маркийн 6730ХОЕ улсын, JN1TCSY61Z0580838 арлын дугаартай суудлын автомашин	10 2011/2011	12,000,000.00	9,000,000.00	3,000,000.00	Ховд аймгийн Булган сум дахь Сум дундын прокурорын газар	Хилийн цэргийн 285 дугаар ангид
НИЙТ ДҮН		1, 10, 10	20,671,425.60	15,891,664.90	4,779,760.70	(дөрвөн сая долоон зуун далан есөн мянга долоон зуун жаран төгрөг далан мөнгө)	
		10	(хорин сая зургаан зуун далан нэгэн мянга дөрвөн зуун хорин таван төгрөг жаран мөнгө)	(арван таван сая найман зуун ерэн нэгэн мянга зургаан зуун жаран дөрвөн төгрөг ерэн мөнгө)			